

## ШИВЭЭГОВЬ СУМЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

/2017.12.25-2018.01.25/

### УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Сумын Засаг даргын 2017 оны 12-р сарын 01-ний өдрийн А/126 тоот Захирамжаар 2017 оны жилийн эцсийн хүн ам, мал тооллогын ажлыг зохион байгуулах комиссыг 23 хүний бүрэлдэхүүнтэй томилон 12-р сарын 07-ны өдрөөс тооллогын ажлыг зохион байгуулж 1068 өрхийн 3449 хүн ам, 48037 толгой мал тоологдсон нь урьд оноос хүн ам 71 өсч, мал 4609 толгой буюу 10,6 хувиар өссөн байна.

Сумын төв шинэ жилийн баяр наадмыг 2017 оны 12-р сарын 30-ны өдөр ШОХК-ийн спорт зааланд ёслол төгөлдөр тэмдэглэж сумын “Тэргүүний ажилтан”-аар - 4, Сумын засаг даргын “Баярын бичиг”-ээр - 4 иргэн шагнагдлаа. Мөн Улс болон ОУ-ын тэмцээн уралдаанд амжилттай оролцсон 20 хүүхэд, сум орон нутагт үнэтэй хувь нэмэр оруулсан 10 иргэн, амьжиргааны баталгаажих түвшинээс доогуур орлоготой өрхийн 27 хүүхдэд өвлийн өвгөний бэлэг гардуулсан.

#### **2017 оны “Тэргүүний ажилтан”-аар**

1. Э.Баярмагнай – ЗДТГ-ын Газрын даамал
2. Ц.Одончимэг – 3-р сургуулийн бага ангийн багш
3. Л.Батцэнгэл – 3-р цэцэрлэгийн багш
4. Д.Болд –Илчлэг-Шивээ ОНӨҮГ-ын сан техникч нар тус тус шалгарсан бол

#### **Засаг даргын баярын бичгээр:**

1. Н.Намуунцэцэг – ЗДТГ-ын Байгаль орчны хяналтын улсын байцаагч
2. Ж.Сүрэн – 3-р сургуулийн үйлчлэгч
3. Д.Нарантуяа – 3-р цэцэрлэгийн тогооч
4. Д.Баяржаргал – ШОХК-ийн ээлжийн мастер нар тус тус шагнагдсан байна.

Сумын Засаг даргын 2017 оны 12-р сарын 01-ний өдрийн А/126 тоот Захирамжаар цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийн ажлыг зохион байгуулж сумын хэмжээнд нийт 910 иргэн хамрагдахаас 750 иргэн хамрагдаж 82,4 хувьтай бүртгэгдсэн байна.

Сумын 2-р багийн нутаг, Хар толгойд нутаглаж байгаа 2-р багийн иргэн Н.Батдэлгэрийн үхэрт шүлхий өвчний шинж тэмдэг илэрсэн нь тогтоогдсон тул Сумын Засаг даргын 2017 оны 12-р сарын 29-ны өдрийн А/142 дугаарт Захирамжаар

“Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж”, мөн өдрийн А/143 дугаарт Захирамжаар суманд “Хорио цээрийн дэглэм” тогтоон ажиллаж байна.

2017 оны 12 сарын 31-ний өдөр Хар амны харнууд, Зүйтийн талын цэнхэр худаг зэрэг газруудад 2 постыг 8 хүний бүрэлдэхүүнтэй гарган ажиллаж байна. Мөн Сүмбэр сумын нутаг Бага мухрын ам гэдэг газарт шүлхий өвчний шинж тэмдэг илэрсэнтэй холбогдуулан Шивээговь сумын зүүн талд төмөр замын гарман дээр 2018 оны 01 сарын 12-ны өдөр дахин нэг пост байгуулан ажиллуулж байна.



Сумын онцгой байдлын комисс сумын төвд 24 цагийн жижүүр хийж 2 цаг тутамд мэдээг холбогдох газруудад өгч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хоригж сумын хэмжээнд 5 машин буюу 4 такси, эмнэлгийн түргэн тусламжийн 1 машинд тогтмол гарч орох зөвшөөрөл олгон ажиллаж байна. Мөн суманд үйл ажиллагаа явуулж буй бүх байгууллагуудыг хуваарилан хөдөлгөөнт эргүүлд гаргаж, "Шивээ Овоо" ХК-тай хамтран суманд байрлах нүхэн гарцуудад шороон далан босгож хаасан.



Сумын нутаг дэвсгэртэй хил залгаа сүмбэр сумын 4 дүгээр багийн хүрийн зоо, улаан усны хоолойн адаг зэрэг газруудад хорогдсон зээрээс дээж авч хүргүүлэхэд улсын мал

эмнэлэг ариун цэврийн лабораторийн шинжилгээгээр шүлхий өвчнөөр хорогдсон болох нь тогтоогдсон тул сумын нутаг дэвсгэрт шүлхий өвчний улмаас хорогдсон байх магадлалтай 22 зээрийн сэг зэмийг /элст, зүйтийн тал, бэлгэхийн улаан өндөр, замын шовх, ширүүн таваг, өвдөг шоовойн говь, хар толгой, модонгийн тасархай зэрэг газруудаас/ цуглуулж, устгаж ариутгал халдваргүйжүүлэлт хийх ажлыг зохион байгуулж ажилласан.



### **ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ**

Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн 2017 оны жилийн эцсийн мэдээг гаргаж ТЗУХ-т хүргүүлсэн. Үүнд:

2017 онд Засаг дарга болон засаг даргын Тамгын газарт 71 өргөдөл, иргэний бүртгэлийн асуудлаар 817 нийт 888 өргөдөл хүлээн авч хугацаанд нь 100% шийдвэрлэн ажилласан.

Сумын Засаг даргын 2017 оны 12-р сарын 20-ны өдрийн А/139 тоот захирамжаар 2017 оны 12-р сарын 20 –оос 2018 оны 01-р сарын 02-ны өдөр хүртэл сумын хэмжээний хариуцлагатай жижүүрийн хуваарийг гарган 8 байгууллагын 28 ажилтан, албан хаагчид байгууллагуудын хэвийн үйл ажиллагаа, нийгмийн хэв журмыг ханган хяналт тавьж ажилласанд ямар нэгэн зөрчил илрээгүй болно.

### **БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ**

#### **3-Р СУРГУУЛЬ :**

Сурагчдын амралтын өдрүүдэд дотоод нөөц бололцоогоо ашиглан сургуулийн багшийн хөгжлийн төв, дотуур байрны багшийн өрөө, нийгмийн ажилтаны өрөөнүүдэд урсгал засварын ажлыг хийж гүйцэтгэсэн.



Аймагт зохион байгуулагдсан шатрын Цодгор хүү тэмцээнд сумаас 8 сурагч оролцож 3б ангийн сурагч Энх-Эрдэнэ Тусгай байр эзэлсэн.

Аймгийн сагсан бөмбөгийн шигшээ багт 3-р сургуулийн 9а ангийн сурагч Э.Одмаа шалгаран орж өсвөр үеийн сагсан бөмбөгийн “УАШТ-2018” тэмцээнд оролцож 2-р байр эзлэн Мөнгөн медаль хүртлээ.



### 3-Р ЦЭЦЭРЛЭГ

Цэцэрлэгийн хүүхдийн ханиад томуугаар өвчилсөн өвчлөл ихсэж, хүүхдийн ирц 50%-иар буурч байна.

Иймд ханиад томуунаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг шат дарааллан авч байна. Үүнд:

Иллэг, давс, содатай уусмалаар хоолой зайлах, хүүхдийг витаминжуулах, жавелиноор ариутгах, өрөө тасалгааг кварцийн гэрлээр халдваргүйжүүлх, хүүхдийн ор дэвсгэрийн хэрэглэлийг салхинд гаргах, чийгтэй цэвэрлэгээ хийх зэрэг халдваргүйтгэлийн

ажлыг өдөр бүр хийж байна. Хүүхдүүдэд халуун аарц, чацаргана, аньсыг өглөө, орой тогтмол өгч байна.

Цэцэрлэгийн 5 бүлэг хоолны хэрэгслийн шкаф, ширээ сандлаар хангагдлаа.

3-р цэцэрлэгт шинээр туршин нэвтрүүлж буй арга зүйн технологийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд бага, дунд бүлгүүд “Гэр”, Бэлтгэл бүлгүүд “Монгол хувцас” төсөлт тоглоомууд, Ахлах бүлэгт “Хот айл” STEAM тоглоомыг сонгон авч сургалтын хөтөлбөрийг боловсруулан үйл ажиллагааг зохион байгуулж байна.

дэлхийн боловсролыг суманд хэрэгжүүлэх зорилгоор STEAM төслийн хүрээнд 2018 оны 01-р сарын 25 –нд 3-р цэцэрлэг дээр аймгийн багш нарын дунд хэлэлцүүлэг зохион байгуулж 40 гаруй багш нар оролцож туршлага солилцлоо.



### **ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ**

- Эмнэлэгт хэвтсэн - 78 үүнээс хүүхэд-46, дотор-40, халдварт 2
- Амбулаторийн үзлэг - 509
- Урьдчилан сэргийлэх –28
- Дуудлага- 239



Осол гэмтлээс сэргийлэх сарын аяны хүрээнд “Миний гэр аюулгүй орчин” уриан дор үйл ажиллагааг эхлүүлэн мэдээлэл сургалт сурталчилгааг зохион байгуулан ажиллаж байна.

2018 оны 01 сарын 15-ны өдөр 3-р цэцэрлэгийн дундын А, Б бүлгийн хүүхдүүдэд гарын ариун цэвэр гараа зөв угаах сэдвээр сургалт зохион байгуулсан.



## ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖ

Өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгааны оноо бодогдсонтой холбогдуулан “Хүнсний эрхийн бичиг”-ийн үйлчилгээнд шинээр хамрагдахаар болсон 11 өрхөд 2017 оны 12-р сарын 29-ний өдөр “Хүнсний эрхийн бичиг”-ийн үйлчилгээтэй холбоотой сургалт зохион байгуулж, 11 өрхийн 68 гишүүнд 11, 12 сарын 1696000 төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг гэрээ байгуулсан дэлгүүрээр дамжуулан олгосон.



“Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хууль”-ийн дагуу 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмжийн өргөдлийг 148 эхээс хүлээн авч хувийн хэргийг бүрдүүлэн ажиллаж байна. Мөн "Цалинтай ээж хөтөлбөр"-ийн хүрээнд 0-3 насны хүүхдээ асарч байгаа эхчүүдийн мөнгөн тэтгэмжийг 2018 оны 01-р сарын 26-ны өдрөөс эхлэн арилжааны хаан болон төрийн банкаар дамжуулан 153 эхэд 7650000 төгрөгийг олгож эхэллээ.

## УЛСЫН БҮРТГЭЛ

2017 оны 12 дугаар сарын 21-нээс 2018 оны дүгээр сарын 19-ны байдлаар Иргэний бүртгэлийн үйлчилгээг 130 иргэнд үзүүлсэн ба үүнээс шинэчилсэн бүртгэлд 8 иргэнийг бүртгэж

баримтыг аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний бүртгэлийн тасагт хүлээлгэн өгч экспорт хийгээд байна.

### ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ 2018 ОНЫ 01 САРЫН МЭДЭЭ

	м/д	Бүгд	Үүнээс:					
			Хот			Хөдөө		
			Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Төрсөн хүүхэд	1	5				5	1	4
Төрсөн эх	2	5				5		5
Бүртгүүлсэн гэр бүл	3	3				3	3	3
Нас баралт	4	2				2	1	1
Цуцалсан гэр бүл	5	0				-	-	-
Үрчлэгдсэн хүүхэд	6	0				-	-	-
Аймаг, нийслэлээс шилжин ирсэн	7	14				14	7	7
Аймаг, нийслэл рүү шилжин явсан	8	9				9	5	4

### ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ШИВЭЭГОВЬ СУМЫН ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНЭЭС ОРСОН ОРЛОГО

2/6/2018

д/д	Үйлчилгээний нэр төрөл	2018 оны 01-р сар					Бүгд	Тайлбар
		Үйлчилгээний хураамж 30020002210 тоот дансанд		Бүгд	Тэмдэгтийн хураамж 300300123138 тоот дансанд			
		Нэг бүрийн үнэ	Тоо		Нэг бүрийн үнэ	Тоо		
1	Эцэг тогтоосны бүртгэл	2500	3	7500				
2	Гэрлэлтийн гэрчилгээний үнэ	2500	3	7500				
3	Иргэний үнэмлэхний үнэ	15000	15	225000	3300	15	49500	
4	Аймаг доторх шилжилт хөдөлгөөн	1500	20	30000	1000	20	20000	
5	Өөр аймаг луу шилжин явсан	2500	7	17500	1000	7	7000	

ДҮН	287500	76500
НИЙТ ДҮН	364000	

### **МАЛ ЭМНЭЛЭГ ҮРЖЛИЙН ТАСАГ**

Хэнтий аймгийн Дархан сумаас отроор орж ирсэн 2 өрх болон голомт үүссэн өрхийн нийт 384 үхэр, 7442 бог малыг вакцинжууллаа.

Малын эмч П.Сарангэрэл 3 хоног тутамд голомтын бүсд байршиж байгаа худгийг ариутгаж голомт үүссэн өрхийн малыг услуулах ажлыг зохион байгуулж байна.

Гоц халдварт шүлхий өвчний голомтын бүсэд 17 өрхийн 57 хүн, 13505 мал байна.

Голомтын бүсийн 17 өрхөд сумын Засаг даргын А/143 дугаар “Хорио цээрийн дэглэм тогтоох тухай” захирамж болон анхааруулга тараах ажлыг хийж гүйцэтгэсэн.

### **ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН**

Сумын 2018 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх "Ахуйн хог хаягдлыг тээвэрлэх, төвлөрсөн хогийн цэгийн хогийг цэвэрлэж, булах" ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо тендерийг 2018 оны 01 сарын 09-ний өдөр зарлаж, үнэлгээ хийхэд "Илчлэг шивээ" ОНӨҮГ-ын ирүүлсэн Тендер нь шаардлагад нийцсэн тендерээр шалгарсан тул Үнэлгээний хорооны зөвлөмж, дүгнэлтийг үндэслэн "Илчлэг шивээ" ОНӨҮГазарт 2018 оны 01 сарын 25-ны өдөр гэрээ байгуулах тухай мэдэгдлийг хүргүүлээд байна.

МЭДЭЭ ГАРГАСАН:

НЗЭЗАХМ

О.БОЛОРМАА